

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018 оны 11-р сарын 13

Тендер шалгаруулалтын нэр: “Монголросцветмет” ХХК-д "Дулааны станцын ус, хими цэвэрлэгээний цогц шинэ систем нэвтрүүлэх. Нийлбэр чадлаараа доорх үзүүлэлтүүдийг хангах автомат шүүлтүүрүүдийн нэгдсэн систем шаардлагатай.

- Шавар элс цэвэрлэх шүүх механик шүүлтүүр-250 шоо метр/цаг
- Усны хатуулгыг 2.6-0.6 экв. болгож бууруулах
- I шатны шүүлтүүр -250 шоо метр/цаг -усны хатуулгыг 1.0-0.6 экв. болгож бууруулах
- II шатны шүүлтүүр -40 шоо метр/цаг" нийлүүлэх

Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/201809360

“Монголросцветмет” ХХК эрх бүхий тендерт оролцогчдоос "Дулааны станцын ус, хими цэвэрлэгээний цогц шинэ систем нэвтрүүлэх. Нийлбэр чадлаараа доорх үзүүлэлтүүдийг хангах автомат шүүлтүүрүүдийн нэгдсэн систем шаардлагатай.

- Шавар элс цэвэрлэх шүүх механик шүүлтүүр-250 шоо метр/цаг
- Усны хатуулгыг 2.6-0.6 экв. болгож бууруулах
- I шатны шүүлтүүр -250 шоо метр/цаг -усны хатуулгыг 1.0-0.6 экв. болгож бууруулах
- II шатны шүүлтүүр -40 шоо метр/цаг" нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэгүй авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000.00 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: *Сүүлийн 2016, 2017 оны аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 100%-иас багагүй байна*  
Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: *2016, 2017 оны санхүүгийн тайлан аудитаар баталгаажсан байх ба дүгнэлтийн хамт ирүүлэх.*

Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх: **Шаардлагагүй**

Тендерийн хамт **2 300,000.00** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2018 оны 12 дүгээр сарын 13-ны өдрийн 15:00 цагаас** өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлэх ба **мөн өдрийн 15:10 цагт** цахим системээр нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Зөвшөөрөнө.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно:

Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98, 409 тоот өрөө, утас: 450060 + 188

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ХХК